

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-/02/2023-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.14 № 01/43
танай -ны № -т

ТӨВ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Д.БАТЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын үйл ажиллагаа, албан хаагчдын ажлын чанар, харилцаа, үйлчилгээний соёлыг иргэдээр үнэлүүлэх цахим системийг Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам, Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр бий болгосон байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газар шинээр цахим сайтад суурилсан дотоод хяналт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны системийг 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн үйлчилгээндээ нэвтрүүлж нийт 5,712 хүнд 66 нэр төрлийн 6,236 үйлчилгээг үзүүлсэн байна. Уг системийг нэвтрүүлснээр үйлчлүүлэгч иргэдийн сэтгэл ханамжийг үнэлэх, албан хаагчдын ажлын ачаалал, үр чадвар, харилцаа хандлагын үнэлгээг хянаж сар бүр хяналт тавьж үйлчилгээг сайжруулах ажлуудыг зохион байгуулах боломжийг бүрдүүлж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторовн мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 1,468.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүй 4,231.2 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж хүлээн авсан дүнгээр үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	52,963,288.00	52,100,788.00
35	БАРАА МАТЕРИАЛ	52,963,288.00	52,100,788.00
354	Хангамжийн материал	52,963,288.00	52,100,788.00
35410	Бичиг хэргийн материал	7,093,100.00	6,772,150.00
35420	Аж ахуйн материал	30,721,090.00	30,329,540.00
35440	Түлш, шатах тослох материал	150,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	14,999,098.00	14,999,098.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,154,603,699.63	1,094,143,853.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,154,603,699.63	1,094,143,853.00
392	Биет хөрөнгө	1,118,470,766.35	1,058,314,886.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,066,793,912.00	1,066,793,912.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-52,237,284.52	-70,909,656.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	50,000,000.00	50,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-50,000,000.00	-50,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	184,221,363.57	189,921,463.57
39206	Хуримтлагдсан элэгдэл	-115,973,517.06	-145,921,714.82
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	72,460,820.90	72,460,820.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	-37,120,288.58	-54,192,818.89
39214	Бусад үндсэн хөрөнгө	488,640.00	488,640.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-162,879.96	-325,759.92
393	Биет бус хөрөнгө	36,132,933.28	35,828,966.56
39301	Програм хангамж	911,900.00	911,900.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-303,966.72	-607,933.44
39303	Бусад биет бус хөрөнгө	35,525,000.00	35,525,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,207,566,987.63	1,146,244,641.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,207,566,987.63	1,146,244,641.00
51	Засгийн газрын хувь оролцоо	1,207,566,987.63	1,146,244,641.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	337,312,636.93	337,312,636.93
51101	Өмч: - төрийн	337,312,636.93	337,312,636.93
512	Хуримтлагдсан үр дүн	760,543,797.55	699,221,450.92
51210	Өмнөх үеийн үр дүн	760,543,797.55	760,543,797.55
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-61,322,346.63
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	109,710,553.15	109,710,553.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,207,566,987.63	1,146,244,641.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	902,430,597.00	1,029,687,926.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,263,743.00	164,698,376.96
120	Нийтлэг татварын бус орлого	33,263,743.00	164,698,376.96
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	33,249,743.00	164,698,376.96
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,954,143.00	161,586,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,295,600.00	3,112,376.96
120009	Бусад орлого	14,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	869,166,854.00	864,989,550.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	799,113,600.00	788,878,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	799,113,600.00	788,878,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	70,053,254.00	76,111,250.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	50,549,254.00	00.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	00.00	28,211,250.00
131103	ЗГНХ ЭДНХ-өөр, түүнтэй адилтах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,514,000.00	600,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,000,000.00	46,100,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	990,000.00	1,200,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	966,119,753.10	1,091,010,273.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	966,119,753.10	1,091,010,273.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	919,894,547.36	1,032,049,314.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	617,734,787.88	656,108,797.05
210101	Үндсэн цалин	440,613,306.93	503,184,579.82
210102	Нэмэгдэл	154,833,480.95	107,534,568.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,288,000.00	21,508,000.00
210104	Урамшуулал	00.00	23,881,648.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,299,866.38	79,198,417.14
210201	Тэтгэврийн даатгал	47,712,901.02	55,261,495.74
210202	Тэтгэмжийн даатгал	4,627,740.55	6,913,724.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,574,511.68	4,886,574.17
210204	Ажилгүйдлийн даатгал	851,429.15	1,092,714.26
210205	Эрүүл мэндийн даатгал	8,533,283.98	11,043,908.47
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,013,210.00	77,332,097.00
210301	Гэрэл, цахилгаан	44,176,544.00	45,285,456.00
210302	Тулш, халаалт	27,086,400.00	29,224,800.00
210303	Цэвэр, бохир ус	3,750,266.00	2,821,841.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,671,847.00	16,817,155.00
210401	Бичиг хэрэг	17,263,860.00	5,988,150.00
210402	Тээвэр, шатахуун	4,716,890.00	3,692,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,108,199.00	540,890.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	306,800.00	253,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,276,098.00	6,342,565.00
2105	Нормативт зардал	11,315,778.00	63,548,069.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,021,400.00	381,360.00
210502	Хоол, хүнс	10,294,378.00	63,166,709.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	469,500.00	1,097,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	469,500.00	1,097,000.00
2107	Томилголт, зочны зардал	2,333,000.00	5,182,000.00
210702	Дотоод албан томилолт	2,333,000.00	5,182,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,613,479.00	67,724,656.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,329,729.00	64,449,254.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,400,000.00	2,344,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	119,250.00	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	35,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	696,500.00	429,000.00
210807	Газрын төлбөр	00.00	349,352.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	77,443,079.10	65,041,123.59
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	77,443,079.10	65,041,123.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,225,205.74	58,960,958.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,386,012.00	24,792,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,406,012.00	23,982,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	980,000.00	810,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,839,193.74	34,168,858.81
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,839,193.74	34,168,858.81
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-63,689,156.10	-61,322,346.63
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,132,218.71	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,132,218.71	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,132,218.71	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-64,821,374.81	-61,322,346.63

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	892,134,997.00	1,026,575,550.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,968,143.00	161,586,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	22,968,143.00	161,586,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,954,143.00	161,586,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,954,143.00	161,586,000.00
120009	Бусад орлого	14,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	869,166,854.00	864,989,550.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	799,113,600.00	788,878,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	799,113,600.00	788,878,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	70,053,254.00	76,111,250.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	50,549,254.00	00.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	00.00	28,211,250.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилгадаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,514,000.00	600,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,000,000.00	46,100,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	990,000.00	1,200,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	890,634,997.00	1,025,106,650.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	890,634,997.00	1,025,106,650.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	844,409,791.26	966,145,691.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	587,885,637.81	592,955,720.05
210101	Үндсэн цалин	477,089,142.47	441,888,378.57
210102	Нэмэгдэл	97,809,899.34	106,528,119.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,986,596.00	20,657,572.73
210104	Урамшуулал	00.00	23,881,648.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,620,666.45	74,705,374.68
210201	Тэтгэврийн даатгал	55,276,295.97	50,937,347.55
210202	Тэтгэмжийн даатгал	6,081,554.09	5,960,881.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,751,002.83	4,748,605.53
210204	Ажилгүйдлийн даатгал	1,135,527.38	1,187,176.39
210205	Эрүүл мэндийн даатгал	11,376,286.18	11,871,363.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,013,210.00	77,332,097.00
210301	Гэрэл, цахилгаан	44,176,544.00	45,285,456.00
210302	Түлш, халаалт	27,086,400.00	29,224,800.00
210303	Цэвэр, бохир ус	3,750,266.00	2,821,841.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,932,747.00	13,403,940.00
210401	Бичиг хэрэг	19,647,760.00	5,602,200.00
210402	Тээвэр, шатахуун	4,134,100.00	3,542,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,260,989.00	540,890.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	306,800.00	253,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,583,098.00	3,465,300.00
2105	Нормативт зардал	10,485,478.00	66,148,784.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	157,500.00	381,360.00
210502	Хоол, хүнс	10,327,978.00	63,193,109.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	2,574,315.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,048,323.00	1,047,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,009,323.00	992,000.00
210604	Урсгал засвар	39,000.00	55,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,333,000.00	5,182,000.00
210702	Дотоод албан томилолт	2,333,000.00	5,182,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57,090,729.00	135,370,775.46
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	53,806,979.00	132,095,373.46
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,400,000.00	2,344,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	119,250.00	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	35,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	696,500.00	429,000.00
210807	Газрын төлбөр	00.00	349,352.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,225,205.74	58,960,958.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,386,012.00	24,792,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,406,012.00	23,982,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	980,000.00	810,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,839,193.74	34,168,858.81
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,839,193.74	34,168,858.81
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,500,000.00	1,468,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,500,000.00	1,468,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,500,000.00	1,468,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,500,000.00	1,468,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,500,000.00	1,468,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1,500,000.00	-1,468,900.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,419,604,574.14	00.00	1,419,604,574.14
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	337,312,636.93	109,710,553.15	760,543,797.55	00.00	1,207,566,987.63
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	337,312,636.93	109,710,553.15	760,543,797.55	00.00	1,207,566,987.63
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	337,312,636.93	109,710,553.15	760,543,797.55	00.00	1,207,566,987.63
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-61,322,346.63	00.00	-61,322,346.63
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	337,312,636.93	109,710,553.15	699,221,450.92	00.00	1,146,244,641.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	951,078,300.00	933,341,091.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	951,078,300.00	933,341,091.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	926,143,300.00	908,548,991.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	599,472,000.00	592,955,720.05
210101	Үндсэн цалин	451,454,600.00	441,888,378.57
210102	Нэмэгдэл	126,165,800.00	106,528,119.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,851,600.00	20,657,572.73
210104	Урамшуулал	00.00	23,881,648.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,934,200.00	74,705,374.68
210201	Тэтгэврийн даатгал	51,041,800.00	50,937,347.55
210202	Тэтгэмжийн даатгал	5,973,100.00	5,960,881.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,778,500.00	4,748,605.53
210204	Ажилгүйдлийн даатгал	1,194,700.00	1,187,176.39
210205	Эрүүл мэндийн даатгал	11,946,100.00	11,871,363.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,455,900.00	77,332,097.00
210301	Гэрэл, цахилгаан	4,248,400.00	45,285,456.00
210302	Түлш, халаалт	65,253,900.00	29,224,800.00
210303	Цэвэр, бохир ус	7,953,600.00	2,821,841.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,881,100.00	6,785,590.00
210401	Бичиг хэрэг	566,400.00	560,200.00
210402	Тээвэр, шатахуун	2,833,600.00	2,276,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,762,600.00	230,890.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	253,200.00	253,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,465,300.00	3,465,300.00
2105	Нормативт зардал	71,175,000.00	64,894,784.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	560,000.00	381,360.00
210502	Хоол, хүнс	67,500,000.00	61,939,109.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,115,000.00	2,574,315.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,687,500.00	2,515,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,618,900.00	2,460,900.00
210604	Урсгал засвар	68,600.00	55,000.00
2107	Томилолт, зочны зардал	80,000.00	64,000.00
210702	Дотоод албан томилолт	80,000.00	64,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	91,457,600.00	89,295,525.46
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	87,360,000.00	86,020,123.46
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,344,800.00	2,344,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	179,500.00	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	102,500.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	42,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	588,300.00	429,000.00
210807	Газрын төлбөр	840,500.00	349,352.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,935,000.00	24,792,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,935,000.00	24,792,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,982,100.00	23,982,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	952,900.00	810,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	951,078,300.00	950,464,300.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	788,878,300.00	788,878,300.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	788,878,300.00	788,878,300.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	162,200,000.00	161,586,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	162,200,000.00	161,586,000.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01	01
610001	Төсвийн байгууллага	01	01
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	53	53
620001	Удирдах ажилтан	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	44	44
620003	Үйлчлэх ажилтан	08	08

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	59,065,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	59,065,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	59,065,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,618,350.00
210401	Бичиг хэрэг	5,042,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,266,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	310,000.00
2105	Нормативт зардал	1,254,000.00
210502	Хоол, хүнс	1,254,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,118,000.00
210702	Дотоод албан томилолт	5,118,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,075,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,075,250.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	76,111,250.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	76,111,250.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	28,211,250.00
131103	ЗГНХЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	600,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	46,100,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,200,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газар нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Нийгмийн халамжийн сан, Захиргаа хяналтын хэлтэс гэсэн 3 нэгж, 53 орон тоогоор үйл ажиллагаа явуулсан байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний төрийн бодлогыг харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий хэрэгжүүлэгч агентлаг байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын үйл ажиллагаа, албан хаагчдын ажлын чанар, харилцаа, үйлчилгээний соёлыг иргэдээр үнэлүүлэх цахим системийг Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам, Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр бий болгосон байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газар шинээр цахим сайтад суурилсан дотоод хяналт, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны системийг 4 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн үйлчилгээндээ нэвтрүүлж нийт 5,712 хүнд 66 нэр төрлийн 6,236 үйлчилгээг үзүүлсэн байна. Уг системийг нэвтрүүлснээр үйлчлүүлэгч иргэдийн сэтгэл ханамжийг үнэлэх, албан хаагчдын ажлын ачаалал, ур чадвар, харилцаа хандлагын үнэлгээг хянаж сар бүр хяналт тавьж үйлчилгээг сайжруулах ажлуудыг зохион байгуулах боломжийг бүрдүүлж ажилласан байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газар доорх зорилтыг хэрэгжүүлэн ажилласан байна.Үүнд:

- Халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж олгох, нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах, үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах
- Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбогдсон иргэд, байгууллагын санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх
- Хүн ам, гэр бүл, нийгмийн хөгжлийг дэмжих чиглэлээр батлагдсан үндэсний хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
- Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгаа, холбогдох бусад баримт бичгийг байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газар ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО ISO 9001:2015 стандарт нэвтрүүлснээр албан хаагч бүрийн албан тушаалын тодорхойлолттой уялдуулж үйл явцын процесс зураглал гаргаж, албан хаагчдын эрхэлж буй албан тушаалд ажлын байрны чиг үүргийн шинжилгээг хийж, гүйцэтгэж буй ажил үүрэг нь тухайн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолттой уялдаж байгаа эсэх болон ажлын ачааллыг тогтоон судалж гаргаснаар ажлын ачааллыг тэнцвэржүүлэн ажиллах боломжийг бүрдүүлж ажилласан байна.

Тус газар нь тайлант онд хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар тусгагдсан 5 зорилт 87 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэн 92,3 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуулийн зарим заалтуудад 2022 оны 4 дүгээр сарын 22, 7 дугаар сарын 05, 11 дүгээр сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- Нийгмийн халамжийн тухай хуулийн зарим заалтуудад 2022 оны 11 дүгээр сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн зарим заалтуудад 2022 оны 4 дүгээр сарын 22-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн "Дотоод хяналтын нэгж томилох тухай" А/65 тушаалаар шинэчлэн томилж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулсан байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын даргын 2020 оны 6 дугаар сарын 19-ны өдрийн А/158 тоот тушаалаар "Дотоод хяналт зохион байгуулалтын журам" боловсруулан баталж мөрдөн ажилласан байна.

Тус байгууллагын дотоод хяналтын нэгж нь дотоод хяналтын календарчилсан төлөвлөгөөнд нийгмийн халамжийн чиглэлээр 7 арга хэмжээ, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр 5 арга хэмжээ, байгууллагын дотоод үйл ажиллагаа, төсөв санхүүгийн чиглэлээр 9 арга хэмжээ нийт 21 арга хэмжээ тусган төлөвлөгөөний хэрэгжилт 95%-тай дүгнэгдэн ажилласан байна.

Тус байгууллагын дотоод хяналтын нэгж нь дотоод үйл ажиллагаанд чиглэсэн хяналт шалгалтыг холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу тогтмолжуулан газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сар бүр, бодлогын баримт бичиг, үндсэн чиглэл, мөрийн хөтөлбөрт тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг улирал бүр тооцон хэрэгжилт хангалтгүй удааширсан, тасарсан арга хэмжээг гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөнд оруулж хэрэгжилтийг хангуулан зөвлөмж өгч ажилласан байна.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2018 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн №А/174 тоот тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг 2018 оны 9 дүгээр сарын 1-ны өдрөөс мөрдөж эхэлсэн байна. Энэхүү баримт бичигт Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын бүртгэл тайлагналын бүртгэлийн үйл ажиллагааг 5 бүлэгт тусгасан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан

бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 61,322.4 мянган төгрөгөөр буюу 5,1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Бараа материал	52,963.3	52,100.8	-862.5
Үндсэн хөрөнгө	1,154,603.7	1,094,143.8	-60,459.9
Нийт хөрөнгө	1,207,567.0	1,146,244.6	-61,322.4
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,207,567.0	1,146,244.6	-61,322.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,207,567.0	1,146,244.6	-61,322.4

Дээрх хүснэгтээс харахад: Тайлант онд үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 1,207,567.0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1,146,244.6 мянган төгрөг болж, 61,322.4 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардлаас шалтгаалжээ. Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 1,468.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүй 4,231.2 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж хүлээн авч үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,146,244.6 мянган төгрөг болж 61,322.4 төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,088,628.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний ерөнхий газраас төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс цалин хөлс, НДШ-ийн зардлыг 74,319.5 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардлыг 10,105.4 мянган төгрөг, дотоод томилолтын зардлыг 2,470.7 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 6,270.4 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардлыг 20,522.9 мянган төгрөг, бусад ажил үйлчилгээний зардлыг 21,550.0 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 6,581.1 мянган төгрөгөөр бууруулж, 946,808.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн хэмнэлтийг хэрэгжүүлж байгаагаас шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тус байгууллагын төсвийг 2022 оны 12 сард Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний ерөнхий газраас 4,270.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 788,878.3 мянган төгрөгөөр улсын төсвөөс, үйл ажиллагааны орлогоос 162,200.0 мянган төгрөг нийт 951,078.3 мянган төгрөгөөр тодотгон ирүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 788,878.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 162,200.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 788,878.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлогоос 162,200.0 мянган төгрөгийг бүрдүүлж, төсөвт 17,123.2 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 933,341.1 мянган төгрөг буюу 98,1 хувьтай байгаа нь цалин хөлс, НДШ-ийн зардал 6,745.1 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардал 123.8 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 2,095.5 мянган төгрөг, норматив зардал 6,280.2 мянган төгрөг, эд хогшил авах зардал 171.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал

2,178,1 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 142.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71902-80101	689,045.3	682,404.6	6,640.7	99.0
2	71902-80103	162,200.0	154,205.9	7,380.1	95.1
3	71902-80802	24,935.0	24,792.1	142.9	99.4
4	72102-80101	74,898.0	71,938.5	2,959.5	96.0
	Дүн	951,078.3	933,341.1	17,123.2	98.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын нэмэлт санхүүжилтийн дансанд “ХОЛТ” олон улсын байгууллагын хүүхдийн амьжиргааг дэмжих төслөөс 28,211.2 мянган төгрөг, дээд шатны захирагчаас 46,100.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц сангаас 600.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,200.0 мянган төгрөг нийт 76,111.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Тус байгууллага тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар хангамж бараа материалын зардалд 6,618.3 мянган төгрөг, норматив зардалд 1,254.0 мянган төгрөг, дотоод томилолтын зардалд 5,118.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 46,075.2 мянган төгрөг нийт 59,065.6 мянган төгрөг зарцуулж 17,045.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71902	2022.01.01 2022.12.31	Нийгмийн халамжийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж эрх зүйн актын хэрэгжилтийг хангах, тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт тусламжид шинээр хамрагдсан болон сунгуулсан иргэдийн мөнгийг програмын түвшинд хянан баталгаажуулж олгох	НХСангийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт тусламжийн олголтын хэрэгжилт 91,1%	876,180.3	861,402.6
2	72102	2022.01.01 2022.12.31	Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилгоор иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилт 92,3%	74,898.0	71,938.5

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 21 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамнаас баталсан 2022 оны төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамнаас баталсан 2022 оны төсвийг, суурь үзүүлэлтийг 2022 оны батлагдсан төсвийн 951,078.3 мянган төгрөгийн нийт зардлаас 1,5 хувиар буюу 14,266.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 10,699.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор дээд шатнаас батлан ирүүлсэн төсвийн хуваарьт хяналт тавин зардлыг санхүүжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 96.8%-тай, 5,0 саяас дээших орлогын 39 гүйлгээ, зарлагын 27 гүйлгээг мэдээлснээс, орлогын 9 гүйлгээ, зарлагын 14 гүйлгээ хугацаа хоцроож байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар худалдан авалт цахим төлбөрийн баримттай холбоотой 2 албан шаардлагыг 100% хэрэгжүүлэн Төв аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын даргын 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 220 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	24,373.4	2	24,373.4	100
Зөвлөмж					
Нийт дүн	2	24,373.4	2	24,373.4	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагад дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,200.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,200.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 445,426.5 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 1,200.0 мянган төгрөгийн алдаа² илэрснээс аудитын явцад 1,200.0 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

1.Тус байгууллага тайлант онд мөнгөн гүйлгээний тайлангийн нэмэлт санхүүжилтийн орлогод төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,200.0 мянган төгрөгийг тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт 445,426.5 мянган төгрөгийн зөрчил³ илэрснээс, 445,426.5 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.2 Зөвлөмж

Илрүүлэлт:

2. Тус байгууллага тайлант онд шилэн дансанд 5,0 саяас дээших орлогын 228,765.8 мянган төгрөгийн 9 гүйлгээ, зарлагын 216,660.7 мянган төгрөгийн 14 гүйлгээ хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 10 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	
							Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайлангийн нэмэлт санхүүжилтийн орлогод төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого тайлагнаагүй байна.	1	1,200.0			1	1,200.0	1	1,200.0
Дүн	1	1,200.0			1	1,200.0	1	1,200.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс	
			Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил				
Шилэн дансанд 5,0 саяас дээших орлогын 228,765.8 мянган төгрөгийн 9 гүйлгээ, зарлагын 216,660.7 мянган төгрөгийн 14 гүйлгээ хугацаа хоцроож байршуулсан байна.	1	445,426.5	1	445,426.5
Дүн	1	445,426.5	1	445,426.5
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил				
Дүн				
Нийт дүн	1	445,426.5	1	445,426.5

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn